МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 21 өдөр Дугаар А/356 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.10, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.6, 22 дугаар зүйлийн 22.2 заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.8-д тусгагдсан "Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын, татвар төлөгчдийн болон бусад холбогдох бүртгэл мэдээллийг тодорхой болгох, татвар ногдох орлогыг үнэн зөв тогтоох ажлыг зохион байгуулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх" заалтад тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх хүрээнд аялал жуулчлалын үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:
М.Хуягбаатар (Аймгийн засаг даргын орлогч)

Гишүүдэд:
Г.Базар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Ч. Хуншагай (Аймгийн татварын хэлтсийн дарга)
Б.Мөнгөнзул (Аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
Б.Ганзориг (Аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)
П.Мөнхжаргал (Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
А.Алтанцоож (Аймгийн Цагдаагийн газрын дарга)
Г.Энхбаяр (Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга)
Д.Эрдэнэболд (Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргааны дарга)

Нарийн бичгийн дарга:
Х.Энхтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

6712010770

2. Ажлын хэсгийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт шалгалтын ажил зохион байгуулах тухай ажлын удирдамж боловсруулан, батлуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатарт)-т үүрэгболгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023